

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны ... дугаар сарын ...-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7 дахь хэсэг, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журмыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Сангийн сайд Б.Жавхлан, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам, орон тооны хязгаар батлах тухай” Монгол улсын Засгийн газрын 2015 оны 513 дугаар тогтоол, “Журамд өөрчлөлт оруулах тухай” Монгол улсын Засгийн газрын 2018 оны 74 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ТАНИЛЦУУЛГА

Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журам шинэчлэх тухай Засгийн газрын тогтоолын танилцуулга

Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль 2015 онд батлагдаж 2016 оноос хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны чиг үүрэгт хэрэгжиж байгаад 2018 оноос боловсрол, шинжлэг ухааны яамны чиг үүрэгт шилжсэн. Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд 2021 оны 11-р сард нэмэлт өөрчлөлт орж, 2022 оны 01-р сараас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны чиг үүрэгт шилжиж ирсэн. Хүүхэд харах үйлчилгээнд 2018 онд 4952 хүүхэд, 2019 онд 4952 хүүхэд, 2020 онд 2818 хүүхэд (үүнээс хөгжлийн бэрхшээлтэй 106 хүүхэд, хилчдийн 156 хүүхэд) тус тус хамрагдсан байна. Ковидын нөхцөл байдлаас шалтгаалан 2021 онд Хүүхэд харах үйлчилгээ эхлээгүй байна.

Хүүхэд харах үйлчилгээг 2022 онд хэрэгжүүлэхээр улсын төсөвт 2.1 тэрбум төгрөг батлагдсан. Төсвийн хүрээнд 2022 оны 1894 хүүхэд (үүнээс 106 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд) хамрагдахаар тооцооллыг холбогдох журмын дагуу хийгээд байна.

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 513 дугаар тогтоол “Журам, орон тооны хязгаар батлах тухай”, тус тогтоолын хавсралтад Монгол улсын Засгийн газрын 2018 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн 74 дүгээр тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Хүүхэд харах үйлчилгээний санхүүгийн дэмжлэг олгох журмын шинэчилсэн төсөлд Боловсрол, шинжлэх ухааны яамны харицдаг байсан заалтыг Гэр бүл, хүүхэд залуучуудын газар болгон өөрчилж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудлыг заалт нэмж тусгасан. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн хүүхэдтэй хамт үйлчилгээнд хамруулах тохиолдолд нэг хүүхэд харагчид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо хоёроос илүүгүй байна

Хүүхэд харах үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дагнан хамруулах тохиолдолд нэг хүүхэд харагчид ногдох хүүхдийн тоо гурваас илүүгүй байна.

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 1.2-т заасан хүүхдийн тооны хязгаарыг үндэслэн аймаг, нийслэлийн боловсролын газарт санхүүгийн дэмжлэгийг сар бүр шилжүүлнэ гэж заасныг Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу ирүүлсэн тайлан, мэдээллийн санд үндэслэн аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагад шилжүүлнэ гэж өөрчилсөн. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүүхэд харах үйлчилгээний мэдээллийн сантай байна гэж тусгасан.

Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухайн сарын 10-ны дотор мэдээг ирүүлнэ.

Санхүүжилтийг Засгийн газраас баталсан “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив” болон хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт олгодог нормативыг баримтлан санхүүгийн дэмжлэгийн хэмжээг тооцож, төлөвлөнө.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьд эмнэлгийн байгууллагын дүгнэлтийн дугаар, огноо;” гэснийг “4.1.2.д) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар комиссын дүгнэлтийн дугаар, огноо;” болгож хялбаршуулсан.

Үйлчилгээнд тавигдах хяналтад дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага хяналт тавьдаг байхаар нэмж тусгасан. Одоо мөрдөгдөж байгаа журмын 85.0%-д өөрчлөлт оруулсан. Энд 6 бүлгийг 5 бүлэг болгож 6 зүйлийг хасаж, 4 заалтыг шинээр нэмж, 5 заалтын нэрийг өөрчилж, 13 заалтыг өөрчлөн найруулж шинэчиллээ.

----oOo----

ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНД САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хүүхэд харах үйлчилгээнд олгох санхүүгийн дэмжлэг (цаашид “санхүүгийн дэмжлэг” гэх)-ийн хэмжээг тооцож төлөвлөх, түүнийг хуваарилах, олгох, зарцуулалтад нь хяналт тавихтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Хүүхэд харагч нь сум, дүүргийн Засаг даргатай гэрээ байгуулах бөгөөд гэрээний загварыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

1.3. Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдах хүүхэд нь төрийн өмчийн болон төрийн өмчийн бус цэцэрлэгт давхар хамрагдаагүй байна.

1.4. Хүүхэд харах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл авсан нэг хүүхэд харагчид оногдох хүүхдийн тоо 5 байна.

1.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад хүүхэдтэй хамт үйлчилгээнд хамруулах тохиолдолд нэг хүүхэд харагчид ногдох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо хоёроос илүүгүй байна.

1.6. Хүүхэд харах үйлчилгээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дагнан хамруулах тохиолдолд нэг хүүхэд харагчид ногдох хүүхдийн тоо гурваас илүүгүй байна.

Хоёр. Санхүүгийн дэмжлэгийн хэмжээг тооцох, төлөвлөх

2.1. Засгийн газраас баталсан “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив” болон хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт олгодог нормативыг тус тус баримтлан санхүүгийн дэмжлэгийн хэмжээг тооцож, төлөвлөн хуваарилна.

2.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үйлчилгээнд хамруулахад “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж норматив”-ыг 2 дахин нэмэгдүүлж тооцно.

2.3. Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгоход шаардагдах хөрөнгийн хэмжээг мэдээллийн сан дахь хүүхдийн тоо, хяналт үнэлгээний дүнд үндэслэн тооцож, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабарын дагуу батлуулах ажлыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн улсын төсөвт батлуулна.

Гурав. Санхүүгийн дэмжлэгийг олгох, хуваарилах

3.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санхүүгийн дэмжлэгийг тухайн төсвийн жилийн 1-5 дугаар сар болон 9-12 дугаар саруудад шилжүүлж дууссан байхаар тооцож, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төсвийн сар, улирлын хуваарьт тусгана.

3.2. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу ирүүлсэн тайлан, мэдээллийн санд үндэслэн аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагад шилжүүлнэ.

3.2.1. хүүхэд харагч нь тухайн сард үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо, ирцийн бүртгэлийн мэдээг хүүхдийн овог, нэр, регистрийн дугаараар гаргаж, дараа сарын 5-ны дотор аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагад хүргүүлнэ.

3.2.2. аймгийн төвийн сумаас бусад суманд үйлчилгээ эрхэлж байгаа хүүхэд харагч нь энэ журмын 3.2.1-д заасан мэдээг мөн хэсэгт заасан хугацаанд сумын Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ. Сумын Засаг даргын Тамгын газар мэдээг нэгтгэж, тухайн сарын 10-ны дотор аймгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллагад цахим болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

3.2.3. аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухайн сарын 15-ны дотор мэдээг ирүүлнэ.

3.2.4. аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь энэ журмын 3.2.1-д заасан мэдээг мөн журмын 4.1-д заасан мэдээллийн сантай тулгаж, зөрчилгүй байгаа тохиолдолд сар бүрийн 30-ны дотор хүүхэд харагчийн харилцах банкны төгрөгийн дансанд санхүүжилтийг шилжүүлнэ.

3.3. Нэг хүүхэд харагчид ногдох хүүхдийн тоо 5-аас бага бол 2 сарын хугацаанд хувь тэнцүүлж санхүүжилт олгох бөгөөд уг байдал 2 сараас илүү хугацаанд үргэлжилсэн тохиолдолд санхүүжилт олгохгүй.

Дөрөв. Хүүхэд харах үйлчилгээний мэдээлэл, хяналт

4.1. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хүүхэд харах үйлчилгээний мэдээллийн сантай байна. Мэдээллийн санд дараах мэдээллийг багтаана.

4.1.1. Хүүхэд харагчийн талаарх мэдээлэл:

- а) овог, эцэг, эхийн нэр, харьяалал;
- б) регистрийн дугаар;
- в) боловсролын түвшинг нотлох баримт бичгийн дугаар, огноо;
- г) хүүхэд харах үйлчилгээний сургалтад хамрагдсаныг нотлох бичиг баримтын дугаар, огноо;
- д) хүүхэд харах үйлчилгээний зөвшөөрөл олгосон сум, дүүргийн Засаг даргын шийдвэрийн дугаар, огноо;
- е) хүүхэд харах үйлчилгээ эрхлэх байрны хаяг;
- ж) холбоо барих утасны дугаар

4.1.2. Хүүхэд харах үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн талаарх мэдээлэл:

- а) овог, эцэг, эхийн нэр, нэр;
- б) эцэг эх, хүүхдийн регистрийн дугаар;
- в) холбоо барих утасны дугаар;
- г) хүүхдийн оршин суух хаяг;
- д) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбар комиссын дүгнэлтийн дугаар, огноо;
- е) цэцэрлэгт хамрагдаагүйг тодорхойлсон орон нутгийн боловсролын байгууллагын тодорхойлолт.

4.2. Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага дараах мэдээллийг маягтын дагуу сар бүрийн 10-ны дотор хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллагад ирүүлнэ.

4.3. Энэ журмын 4.2-т заасан мэдээний маягтыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

4.4. Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хүүхэд харах үйлчилгээний мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын талаар зөвлөмж, аргачлал гаргаж,

холбогдох байгууллага, албан тушаалтныг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

4.5.Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага нь боловсролын байгууллагатай хамтран хүүхэд харах үйлчилгээ болон сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж байгаа хүүхдийн давхардлыг улиралд нэгээс доошгүй удаа шалгана.

4.6.Хүүхэд харах үйлчилгээнд олгосон санхүүгийн дэмжлэгийн зарцуулалтад төрийн болон төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч хяналт тавина:

Тав.Бусад

5.1.Аймаг, нийслэл, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан байгууллага, боловсролын байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллага нь хяналтаар илэрсэн зөрчлийг арилгаагүй хүүхэд харагчид олгох санхүүгийн дэмжлэгийг зогсоох, зөвшөөрлийг хүчингүй болгох санал, дүгнэлтийг зөвшөөрөл олгосон этгээдэд хүргүүлж шийдвэрлүүлнэ.

5.2.Санхүүгийн дэмжлэгийг зориулалтын бус зүйлд зарцуулсан, цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийг хүүхэд харах үйлчилгээний бүртгэлд оруулж, хуурамч мэдээ, тайлан өгсөн хүүхэд харагч, сарын мэдээг санаатай буруу мэдүүлсэн албан тушаалтанд Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйл болон Төсвийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.